



ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ТЭТГЭВРИЙН АСУУДЛААР
ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ

**ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД НЭМЭГДЭЖ ГАРАХ
ЗАРДЛЫН ТООЦОО**

Улаанбаатар хот
2025 он

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийн "Хэлэлцээр соёрхон батлах тухай" хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал" (цаашид "аргачлал" гэх)-ын дагуу тооцлоо.

Зардал тооцсон субъект:

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийн "Хэлэлцээр соёрхон батлах тухай" хуулийн төслийн зорилт нь гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа иргэдийн нийгмийн хамгааллын баталгааг сайжруулах зорилгоор Монгол Улс болон Бүгд Найрамдах Казахстан Улсын иргэдийн хоёр улсад 1998 оноос өмнө ажилласан (даатгуулсан) цаг хугацааны хувьд давхцаагүй хугацааг нэгтгэн тооцож, өндөр насны тэтгэвэр тогтоох, Монгол Улсын иргэд 1998 оноос хойш БНКУ-ын хуримтлалын тэтгэвэрт хамрагдсан бол өөрийн улсдаа БНКУ-ын хуримтлалын тэтгэврийг шилжүүлэх авах харилцааг тодорхойлоход оршиж байгаа тул аж ахуйн нэгж, байгууллага, даатгуулагч, төрийн байгууллагад үзүүлэх нөлөөллийн зардлыг тооцов.

I. УЛСЫН ТӨСӨВТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд нийгмийн даатгалын сангийн орлогод нөлөө үзүүлэхгүй. Харин нийгмийн даатгалын сангийн зардалд дараах нөлөө үзүүлэхээр байна. Үүнд:

Хэлэлцээрийн 3-5 дугаар зүйлд хэлэлцээрийн хүрээнд тэтгэвэр тогтоож олгох, ажилласан (даатгуулсан) хугацааг нэгтгэн тооцох харилцааг зохицуулсан. Ингэхдээ шимтгэл төлсөн нийт хугацаанаас тухайн улсад шимтгэл төлсөн хугацаанд ногдох тэтгэврийг олгох зохицуулалтыг тусгасан. Үүнтэй холбоотойгоор Хэлэлцээрийн хүрээнд тэтгэврийн даатгалын сангаас тэтгэврийн зардал гарна.

Тухайлбал, Монгол Улсын иргэн өөрийн улсдаа 12 жил, Казахстан Улсад 14 жил нийгмийн даатгалын шимтгэл төлсөн, хоёр улсын тэтгэврийн насанд хүрсэн гэвэл хоёр улсад шимтгэл төлсөн хугацаагаа нэгтгэн 26 жилээр тооцуулж, тэтгэврийн эрх үүсгэх бөгөөд Монгол Улсаас шимтгэл төлсөн 12 жилд ногдох тэтгэврийг, Казахстан Улсаас 13 жилд ногдох тэтгэврийг тус тус тогтоолгох авах боломжтой болно. Мөн Монгол Улсын иргэн Казахстан Улсад 1998 оноос хойш шимтгэл төлсөн бол тус улсаас төлсөн шимтгэлтэй уялдсан хуримтлалын тэтгэврийг тогтоолгож, Монгол Улсдаа шилжүүлэн авах эрх үүснэ.

Гадаад харилцааны яамны мэдээллээр 2023 оны байдлаар БНКУ-д Монгол Улсын 8,036 иргэн оршин сууж байгаагаас 3,115 иргэн албан ёсоор ажил хөдөлмөр эрхэлж байгаа бол Гадаадын иргэн, харьяатын газрын мэдээллээр Монгол Улсад БНКУ-ын 564 иргэн оршин сууж байна.

Хэлэлцээр хэрэгжсэнээр нийгмийн даатгалын сангаас зардал гарах боловч иргэдийн нийгмийн хамгааллын баталгаа нь сайжрах эерэг нөлөөтэй.

Харин хэлэлцээргүй нөхцөлд тухайн иргэн хоёр улсын хуулийн дагуу тэтгэвэр авахад шимтгэл төлсөн байх хугацаа, нас, иргэний харьяаллын шаардлагыг хангахгүй нөхцөлд нийгмийн хамгааллын баталгаа нь алдагдах эрсдэлтэй бөгөөд

ингэснээр улсын төсвөөс буюу нийгмийн халамжийн сангаас насан туршдаа тэтгэвэр авах нөхцөл үүсэх юм.

II. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийн “Хэлэлцээр соёрхон батлах тухай” хуулийн төслийн хүрээнд ажил олгогчид нэмэлт зардал үүсгэх хуулийн зохицуулалт ороогүй болно. Хуулийн этгээдийн хувьд хууль тогтоомжид заасан үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан шинээр ажлын байр нэмэгдэхгүй юм.

III. ИРГЭН /ДААТГУУЛАГЧ/-Д ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр (хэлэлцээр)-ийн “Хэлэлцээр соёрхон батлах тухай” хуулийн төслийн хүрээнд даатгуулагчид нэмэлт зардал үүсгэх хуулийн зохицуулалт ороогүй болно.

IV. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Хэлэлцээрт иргэнээс тэтгэвэр тогтоолгох өргөдөл хүлээн авах, ажилласан (даатгуулсан) хугацаа баталгаажуулах, тэтгэвэр шилжүүлэхтэй холбоотой дараах зохицуулалт туссан бөгөөд зардлыг дараах байдлаар тооцлоо. Үүнд:

1. Тэтгэвэр тогтоохтой холбоотой зардал

Хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн 1-т “Талуудын улсын иргэдийн тэтгэврийг оршин сууж буй улсын хууль тогтоомжийн дагуу тогтоох ба олгоно” гэж, мөн зүйлийн 6 дахь хэсэгт “Монгол Улсад өндөр насны тэтгэвэр тогтоолгох, Бүгд Найрамдах Казахстан Улсад өндөр насны тэтгэврийн төлбөр тогтоолгох өргөдлийг оршин суугаа улсын хууль тогтоомжид заасан шаардлагатай баримт бичгийг хавсарган оршин суугаа улсын эрх бүхий байгууллагад гаргана” гэж, 6 дугаар зүйлийн 3-т “Нөгөө Талын улсын нутаг дэвсгэрт ажилласан (даатгуулсан) хугацааг баталгаажуулах зорилгоор, түүнчлэн тэтгэвэр тогтоох, олгох, зогсоох болон энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад асуудлаар нэмэлт мэдээлэл, баримт бичиг авах шаардлагатай тохиолдолд нэг Талын эрх бүхий байгууллага нь нөгөө Талын эрх бүхий байгууллагад хүсэлт гаргана” гэж тус тус заасантай холбогдуулан дараах тооцоог хийв.

Монгол Улсын тухайд хэлэлцээрийг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага нь Нийгмийн даатгалын ерөнхий газар (НДЕГ) бөгөөд гадаад хамтын ажиллагаа, нийгмийн хамгааллын хэлэлцээр хариуцсан ахлах мэргэжилтэн ажиллаж байна. Иймээс НДЕГ-ын хувьд хүний нөөцийн нэмэлт зардал шаардагдахгүй буюу хууль тогтоомжид заасан үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан шинээр ажлын байр нэмэгдэхгүй юм.

Харин хэлэлцээрийн хүрээнд иргэн тэтгэвэр тогтоолгох ажилласан жилээ баталгаажуулах өргөдлийг НДЕГ-т гаргах бөгөөд тус газар нь иргэний Бүгд Найрамдах Казахстан Улсад ажилласан, даатгуулсан хугацааг баталгаажуулах зорилгоор тус улсын эрх бүхий байгууллагад иргэний баримт бичгийн хуулбарлан

явуулах, эсхүл БНКУ-аас ирүүлсэн мөн ажилласан, даатгуулсан жилийг баталгаажуулах хүсэлтийн хариуг илгээхтэй холбоотой зардал гарна. Тиймээс тэтгэвэр тогтоолгох өргөдлийг НДЕГ-т гаргасан иргэний баримт бичгийг шалгах, ажилласан, даатгуулсан хугацааг баталгаажуулахтай холбоотой гарах бичиг хэрэг, шуудангийн зардлын тооцоо хийлээ. Үүнд:

№	Ерөнхий стандарт үйл ажиллагаа	Хугацаа (минут)	Бичиг хэргийн зардал (төгрөг)
1.	Үүрэгтэй танилцах	5	-
2.	“Бүгд Найрамдах Казахстан Улсын нутаг дэвсгэрт ажилласан (даатгуулсан) хугацааг баталгаажуулах хүсэлт” маягт хэвлэх зардал (2 нүүр)	2	40₮ x 2 ш + 93₮ x 2 нүүр = 266₮
3.	Өргөдөл гаргасан иргэний ажилласан хугацааг тооцоолох, Мэдээллийн технологийн нэгжээс мэдээллийг нягтлах	8	-
4.	Иргэний тэтгэвэр тогтоолгох баримт бичгийг хуулбарлах (~10 нүүр)	5	40₮ x 10 ш + 93₮ x 10 нүүр = 1330₮
5.	Албан бичиг боловсруулах (1 нүүр)	10	40₮ x 1 ш + 93₮ x 1 нүүр = 133₮
6.	БНКУ-ны эрх бүхий байгууллагад илгээх шуудангийн зардал	2	0.2гр = 12,600 ¹ төгрөг
Нэг тохиолдлыг шийдвэрлэх хугацаа, зардал		32 минут	14,329 төгрөг
		32 мин x 405.4₮ ² = 25,773₮	

Тайлбар: Бичгийн цаас³, принтерийн хорны⁴ зардлаар тооцов.

Талуудын эрх бүхий байгууллагууд нь иргэний тэтгэвэр тогтоохтой холбоотой мэдээллийг цахим хэлбэрээр солилцох боломжтой. Тиймээс нэг иргэний тэтгэвэр тогтоолгох өргөдлийг шийдвэрлэхтэй холбоотой 14,329 төгрөгийн бичиг хэргийн зардал нь зөвхөн шаардлагатай тохиолдолд гарах юм.

Мөн НДЕГ-т хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинэ ажлын байр бий болохгүй, орон тоо нэмэхгүй учир 25,773 төгрөгийн цалингийн зардал нэмж гарахгүй юм.

2. Тэтгэвэр шилжүүлэхтэй холбоотой зардал

Хэлэлцээрийн хүрээнд БНКУ-аас Монгол Улсын иргэд хуримтлалын тэтгэврийг Монгол Улс дахь банкны дансандаа шилжүүлэн авах харилцааг зохицуулсан.

Тухайлбал, хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн 4-т “Бүгд Найрамдах Казахстан Улсын хуримтлалын тэтгэврийг Бүгд Найрамдах Казахстан Улсын хууль тогтоомжид заасан журам болон нөхцөлийн дагуу тэтгэврийн хуримтлалын нэгдсэн сангаас олгоно” гэж, мөн зүйлийн 5-д “Тэтгэвэр шилжүүлэхтэй холбогдсон нийт зардлыг тэтгэвэр тогтоож буй Тал хариуцна” гэж, 5 дугаар зүйлд “Тэтгэвэр авагч Бүгд Найрамдах Казахстан Улсаас Монгол Улсад байнга оршин суухаар гарсан тохиолдолд хуримтлалын тэтгэврийг шилжүүлнэ”, мөн зүйлийн 2-т “Хуримтлалын

¹ Монгол шуудан ХК-ны гадаад шуудангийн тарифаар тооцов, <https://www.mongolpost.mn/price-calc>

² Төрийн албаны ТЗ-6 шатлалын цалин 1,933,000₮, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17089709806371&showType=1>

³ Цагаан өнгийн А4 хэмжээ 500 ширхэгтэй бичгийн цаас, үнэ 20,280₮, <https://nomin.mn/v/19469/19515/27124>

⁴ Принтерийн хор (HP LaserJet 125A) 1400 хуудас хэвлэх, үнэ 129,900₮, <https://bsb.mn/products/by-code/HP-CB543A-M>

тэтгэврийг гүйлгээ хийсэн өдрийн Бүгд Найрамдах Казахстан Улсын валютын албан ханшаар Монгол Улсын үндэсний валютад хөрвүүлж, тэтгэвэр авагчийн дансанд шилжүүлнэ” гэж тус тус заасан.

Тиймээс БНКУ-ын хуримтлалын тэтгэврийг Монгол Улсын иргэнд олгохтой холбоотой зардлыг БНКУ-ын эрх бүхий байгууллагаас хариуцах тул НДЕГ-аас нэмэлт зардал гарахгүй юм.

---oOo---